



НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

Даргын дэргэдэх зөвлөлийн гишүүдийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" А/164 дүгээр захирамжийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг, газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.6, 1.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэг, газрын өмнө тавигдсан зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар зөвлөх эрх бүхий газрын даргын дэргэдэх Зөвлөлийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Гишүүд:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга

Агаарын чанарын хэмжилт, зохион
байгуулалтын хэлтсийн дарга

Хяналт, шалгалтын хэлтсийн дарга

Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан
ахлах мэргэжилтэн

Түлшний бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн

Байгаль орчны улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

Өргөдөл гомдол, шуурхай асуудал хариуцсан
ажилтан

2. Газрын даргын дэргэдэх зөвлөл нь байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэг, газрын өмнө тавигдсан зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхдээ баталсан журмын дагуу хуралдаж, нууцын баталгаа гарган ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2022 оны А/20 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ГАНБОЛД

1150500050



Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны 03 дугаар сарын 06 -ны өдрийн 126 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

“НУУЦЫН БАТАЛГААНЫ ХУУДАС”

(Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэг, газрын өмнө тавигдсан зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар зөвлөх, санал, дүгнэлт гаргах хүрээнд хууль тогтоомжоор төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцад хамруулсан мэдээ, мэдээлэл, баримт бичиг зэрэгтэй танилцаж, хэлэлцэн ярилцахдаа нууц задруулахгүй байх талаар Газрын даргын дэргэдэх зөвлөлийн гишүүн миний гаргах баталгаа)

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газарт ажилтай овогтой би Монгол Улсын Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуульд заасан албан ажлын шаардлага, ажил үүргийнхээ дагуу хууль тогтоомжоор нууцад хамааруулсан мэдээ, мэдээлэл, баримт бичиг зэрэг албаны нууцлалыг задруулахгүй гэдгээ баталж, энэхүү “Нууцын баталгаа”-г гаргаж байна.

Газрын даргын дэргэдэх зөвлөлийн гишүүн би албаны нууцтай холбоотой нууцыг задруулбал холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх болно.

БАТАЛГАА ГАРГУУЛСАН:

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ
БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

(гарын үсэг, тамга)

Ц.ГАНБОЛД
(овог, нэр)

НУУЦЫН БАТАЛГАА ГАРГАГЧ:

ГАЗРЫН ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

(гарын үсэг)

.....
(овог, нэр)

20..... оны дугаар сарын –ны өдөр